



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/113

Бат-Өлзий сум

Тээврийн хэрэгслийн албан татвар хураах, техникийн хяналтын үзлэг явуулах, жолоочийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, Монгол Улсын Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, Жолоочийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн хяналтын үзлэг явуулах, албан татвар, орон нутгийн замын санг бүрдүүлэх, жолоочийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах сумын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)

Гишүүд:

Н.Батсайхан (Татварын улсын байцаагч)

Д.Энх-Амгалан (Цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн хошууч)

Ж.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)

Д.Бямбасүрэн (2 дугаар багийн Засаг дарга)

С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)

Г.Пүрэвтогтох (4 дүгээр багийн Засаг дарга)

Г.Бямбагарав (5 дугаар багийн Засаг дарга)

Д.Дэмиддагва (6 дугаар багийн Засаг дарга)

Ц.Маргад-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын нярав)

Ж.Батмөнх (Байгаль хамгаалагч)

2.Сумын ажлын хэсгийн дарга (Н.Орхонтуул)-д ДААЛГАХ нь.

а.Сумын хэмжээнд Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар хураах замын санг бүрдүүлэх, даатгалд хамруулах, техникийн хяналтын үзлэг явуулах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллах.

б.Тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэд, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийг үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах.

в.Сумын иргэдийн өмчлөлд байгаа өөр аймгийн болон Улаанбаатар хотын улсын дугаартай тээврийн хэрэгслүүдийг орон нутагт шилжүүлж, татварын орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх.

г.Улсын бүртгэлд бүртгэгдээгүй, улсын дугааргүй, замын хөдөлгөөнд оролцож байгаа мотоциклыг бүртгэлд хамруулж, дугааржуулах.

д.Өөрийн аймагт харьяалагдах сүүлийн 3 жилд техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй, шилжилт хөдөлгөөн хийгдээгүй, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар төлөөгүй, улсын бүртгэлээс хасах шаардлагатай, өөрийн аймагт харьяалагдах тээврийн хэрэгслүүдийг улсын бүртгэлээс хасалт хийх ажлыг зохион байгуулах.

г.Батлагдсан хуваарь графикайн дагуу 2024 оны 05 дугаар сарын 27- оос 06 дугаар сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулах.

3.Техникийн үзлэгийн өдрүүдэд нийгмийн хэв журмыг сахиулах, Автотээврийн хэрэгслийн хяналтын үзлэг оношлогоонд бүрэн хамруулах ажлыг ажлын хэсэгтэй хамтран зохион байгуулахыг Цагдаагийн тасгийн дарга (Д.Энх-Амгалан цагдаагийн ахмад), ажлын хэсгийн дарга (Н.Орхонтуул) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН